

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тэс сумын Хар үзүүр хүний их эмчийн салбарын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/147/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: М. Батсуурь

Утас: 70453317

Аудитын менежер:

Утас: 70453799

Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн Ариун төгс оршихуй Аудит

ХХК-ийн аудитор:

Утас: : 99023656

Цахим хаяг: batsuuriM@audit.gov.mn

Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

В.Сэлэнгэ

Цахим хаяг: ariuntuqsorshihuaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ТЭС СУМЫН ХАР ҮЗҮҮР
ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН САЛБАРЫН
ДАРГА М.ЛХАГВАЖАВ ТАНАА

2023.02.24 № УВА-2023/14/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэс сумын Хар үзүүр хүний их эмчийн салбарын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тэс сумын Хар үзүүр хүний их эмчийн салбарын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200000145

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд ~~үндэслэн гарах хөрөглөгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал~~ материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,711,585.00	7,388,626.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	697,472.00	00.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	697,472.00	00.00
3121	Төгрөг	697,472.00	00.00
31211	Төрийн сангийн харилцах	697,472.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	5,014,113.00	7,388,626.00
351	Түүхий эд материал	2,182,138.00	141,659.00
35130	Эм боох материал	2,182,138.00	141,659.00
354	Хангамжийн материал	2,831,975.00	7,246,967.00
35420	Аж ахуйн материал	1,359,000.00	1,359,000.00
35440	Түлш, шатах тослох материал	102,564.00	4,852,564.00
35460	Хүнсний материал	370,411.00	35,403.00
35470	Бусад хангамжийн материал	1,000,000.00	1,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	51,033,950.99	43,906,108.03
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	51,033,950.99	43,906,108.03
392	Биет хөрөнгө	41,033,950.99	33,906,108.03
39201	Барилга, байгууламж, орон сууц	19,427,021.44	19,427,021.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,666,638.36	-2,222,184.48
39203	Авто-тээврийн хэрэгсэл	49,260,000.00	33,220,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	28,992,499.88	18,782,500.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	5,573,965.20	5,573,965.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-2,567,897.41	-3,310,194.13
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,789,494.00	1,789,494.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-1,789,494.00	-1,789,494.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,500,000.00	3,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,500,000.00	-3,500,000.00
393	Биет бус хөрөнгө	10,000,000.00	10,000,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,000,000.00	10,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	56,745,535.99	51,294,734.03
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	56,745,535.99	51,294,734.03
51	Засгийн газрын хувь оролцоо	56,745,535.99	51,294,734.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	20,246,253.82	20,246,253.82
51101	Өмч: - төрийн	20,246,253.82	20,246,253.82
512	Хуримтлагдсан үр дүн	17,072,260.73	11,621,458.77
51210	Өмнөх үеийн үр дүн	17,072,260.73	17,072,260.73
51220	Тайлант үеийн үр дүн		-5,450,801.96
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	19,427,021.44	19,427,021.44
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	56,745,535.99	51,294,734.03

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	160,644,872.96	13,360,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	149,695,900.00	00.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	149,695,900.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	149,695,900.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,948,972.96	13,360,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	13,360,000.00	13,360,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,360,000.00	13,360,000.00
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	-2,411,027.04	00.00
1330	Төсвийн захирагчдаас	-2,411,027.04	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	166,834,304.84	18,810,801.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	166,834,304.84	18,810,801.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	166,834,304.84	9,984,420.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	104,454,580.00	00.00
210101	Үндсэн цалин	92,629,510.00	00.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,080,461.00	00.00
210104	Урамшуулал	9,744,609.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,616,800.00	00.00
210201	Тэтгэврийн даатгал	13,311,200.00	00.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,076,400.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	861,100.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	215,300.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,152,800.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,507,972.96	31,090.50
210301	Гэрэл, цахилгаан	817,972.96	31,090.50
210302	Түлш, халаалт	9,642,000.00	00.00
210303	Цэвэр, бохир ус	48,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,034,340.00	00.00
210401	Бичиг хэрэг	398,600.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	6,714,640.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	829,500.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	746,600.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,345,000.00	00.00
2105	Нормативт зардал	12,638,047.00	2,375,487.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,722,657.00	2,040,479.00
210502	Хоол, хүнс	2,820,390.00	335,008.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,095,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,495,000.00	450,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	460,000.00	00.00

210604	Урсгал засвар	1,035,000.00	450,000.00
2107	Томилолт, зочны зардал	100,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	100,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	395,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	60,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	30,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	260,000.00	00.00
210807	Газрын төлбөр	45,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,592,564.88	7,127,842.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,554,600.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,037,964.88	7,127,842.96
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		8,826,381.50
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		8,128,909.50
	Төвлөрүүлэх шилжүүлэг		8,128,909.50
	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	697,472.00
	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	0.00	697,472.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-6,189,431.88	-5,450,801.96
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-6,189,431.88	-5,450,801.96

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	160,644,872.96	13,360,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	149,695,900.00	00.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	149,695,900.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	149,695,900.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,948,972.96	13,360,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	10,948,972.96	13,360,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,360,000.00	13,360,000.00
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	-2,411,027.04	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	159,947,400.96	14,057,472.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	159,947,400.96	14,057,472.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	159,947,400.96	5,231,090.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	107,539,880.00	00.00
210101	Үндсэн цалин	95,714,810.00	00.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,080,461.00	00.00
210104	Урамшуулал	9,744,609.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,531,500.00	00.00
210201	Тэтгэврийн даатгал	10,225,900.00	00.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,076,400.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	861,100.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	215,300.00	00.00

210205	Эрүүл мэндийн даатгал	2,152,800.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,507,972.96	4,781,090.50
210301	Гэрэл, цахилгаан	817,972.96	31,090.50
210302	Түлш, халаалт	9,642,000.00	4,750,000.00
210303	Цэвэр, бохир ус	48,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,156,440.00	00.00
210401	Бичиг хэрэг	540,100.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	6,498,850.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	829,500.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	799,490.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,488,500.00	00.00
2105	Нормативт зардал	12,991,108.00	00.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,494,308.00	00.00
210502	Хоол, хүнс	2,496,800.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,930,900.00	450,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,489,900.00	00.00
210604	Урсгал засвар	441,000.00	450,000.00
2107	Томилолт, зочны зардал	100,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	100,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	395,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	60,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	30,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	260,000.00	00.00
210807	Газрын төлбөр	45,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,794,600.00	00.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,794,600.00	00.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,411,027.04	8,826,381.5
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,411,027.04	8,128,909.5
	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,411,027.04	8,128,909.5
	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		697,472.00
	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт		697,472.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,187,372.00	-697,472.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,489,900.00	
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,489,900.00	
	Дотоод эх үүсвэрээр	1,489,900.00	
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,489,900.00	
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,489,900.00	
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	697,472.00	-697,472.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	697,472.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	697,472.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	20,246,253.82	19,427,021.44	17,072,260.73	56,745,535.99
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,246,253.82	19,427,021.44	17,072,260.73	56,745,535.99
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-5,450,801.96	-5,450,801.96
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,246,253.82	19,427,021.44	11,621,458.77	51,294,734.03

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,360,000.00	5,231,090.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,360,000.00	5,231,090.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,360,000.00	5,231,090.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,360,000.00	4,781,090.50
210301	Гэрэл, цахилгаан	850,000.00	31,090.50
210302	Түлш, халаалт	12,000,000.00	4,750,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	450,000.00
210604	Урсгал засвар	00.00	450,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	00.00	5,231,090.50
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	13,360,000.00	5,231,090.50
132001	Орон нутгийн төсвөөс	13,360,000.00	5,231,090.50
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	697,472.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	09.00	09.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	04.00	04.00
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тэс сумын Хар үзүүр хүний их эмчийн салбар нь иргэн бүрд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, чирэгдэлгүй нээлттэй, түргэн шуурхай үзүүлж, хүн амын өвчлөл эндэгдлийг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэс сумын Хар үзүүр хүний их эмчийн салбарын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тэс сумын Хар үзүүр хүний их эмчийн салбарын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,450.8 мянган төгрөгөөр буюу 9.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	697.4	0	-697.4
Авлага	0	0	0
Бараа материал	5,014.10	7,388.60	2,374.50
Үндсэн хөрөнгө	51,033.90	43,906.10	-7,127.80
Нийт хөрөнгө	56,745.50	51,294.70	-5,450.80
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	56,745.50	51,294.70	-5,450.80
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	56,745.50	51,294.70	-5,450.80

Мөнгөн хөрөнгө, авлагын эцсийн үлдэгдэл байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 7,388.6 мянган төгрөг болж 2,374.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдан авсан бараа материалын зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 43,906.1 мянган төгрөг болж 7,127.8 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Засгийн газрыг хувь оролцоо дансны үлдэгдэл 51,294.7 мянган төгрөг болж 5,450.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс батлаагүй ба энэ нь үйл ажиллагааг зогсоож, сумын Эрүүл мэндийн төвтэй нэгдсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсөв нь Тэс сумын Хар үзүүр хүний их эмчийн салбар нь Эрүүл мэндийн төвийн төсөвт нэмэгдэж баталсан бөгөөд орон нутгийн төсвөөс 13,360.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 13,360.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 5,231.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	13,360.0	5,231.2	8,128.8	39.2%

Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ хөтөлбөр арга хэмжээний байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 8,128.8 мянган төгрөгөөр хэмнэгдсэнийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Тэс сумын Хар үзүүр хүний их эмчийн салбарын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Тэс сумын Хар үзүүр хүний их эмчийн салбар нь эрүүл мэндийн үйл ажиллагаа явуулдаг, Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын үндсэн мэдээлэл, түүний гадаад орчин болон дотоод үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн үйл явцыг судалж, ойлгосноор эрсдэлтэй асуудлыг тодорхойлж баримтжуулав.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Ариун төгс оршихуй Аудит” ХХК-ийн аудитор В.Сэлэнгэ гүйцэтгэж, хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлэн ажиллаа.

Тэс сумын Хар үзүүр хүний их эмчийн салбарын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ариун төгс оршихуй аудит ХХК-нд 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 54 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн үе шатанд 2022 оны санхүүгийн тайлан бүрэн тайлагнагдаагүй байсан тул материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг өмнөх он буюу 2021 оны санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлын дүнгээр суурь үзүүлэлтийг сонгосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 18,810.8 мянган төгрөгийн 1 хувь буюу 188.1 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 150.4 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 149, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тэс сумын Хар үзүүр хүний эмчийн салбар нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

"АРИУН ТӨГС ОРШИХУЙ АУДИТ"
ХХК-ийн АУДИТОР /В.СЭЛЭНГЭ/

2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр

